

**ЭРҮҮГИЙН ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН
ТӨСӨЛ БОЛОН ХАМТ ӨРГӨН МЭДҮҮЛСЭН ХУУЛИЙН ТӨСЛҮҮДИЙГ ЭЦСИЙН
ХЭЛЭЛЦҮҮЛЭГТ БЭЛТГЭСЭН ТАЛААРХ ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ТАНИЛЦУУЛГА**

2023 оны 11 дүгээр
сарын 15-ны өдөр

Улаанбаатар
хот

Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд зэ,

Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 10 дугаар сарын 13-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг Улсын Их Хурал 2023 оны 11 дүгээр сарын 09-ний өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед хуралдаан даргалагчаас өгсөн гүйцээн боловсруулах чиглэлийн дагуу Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1-д заасныг баримтлан 1 санал хураалт явуулж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн бөгөөд Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүд хуулийн төслийн зарим заалтаар дахин санал хураах шаардлагатай гэж үзсэн тул Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.3-т заасныг баримтлан 1 санал хураалт явуулж хуралдаанд оролцсон гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь дэмжсэн болно.

Нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан саналуудыг төсөлд нэмж тусган төслийн агуулга, бодлого, зарчмыг алдагдуулахгүйгээр үг хэллэг, дэс дараалал, бутцийн шинжтэй засварыг хийж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төсөл болон Байнгын хорооны танилцуулгыг Та бүхэнд хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд зэ,

Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Хууль зүйн байнгын хорооны танилцуулгыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА**

Д.ЦОГТБААТАР



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
 хот

ЭРҮҮГИЙН ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Эрүүгийн хуульд доор дурдсан агуулгатай дараах хэсэг, тайлбар нэмсүгэй:

1/1.10 дугаар зүйлийн 10 дахь хэсэг:

"10. Гэмт хэрэг үйлдэх үедээ арван найман насанд хүрээн хүн энэ хуулийн 12.1 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг, 12.3 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, 13.1 дүгээр зүйлийн 2.1-д заасан гэмт хэрэг үйлдсэн бол гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацаа нь гэмт хэрэг үйлдсэн өдрөөс хойш түчин жил байна."

10. Энэ хуулийн 12.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, 12.3 дугаар зүйлийн 2.1, 3.2 дахь заалт, 13.1 дүгээр зүйлийн 2.1-д заасан гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацаа тоолохыг зогсоож, хохирогчийг арван найман насанд хурсний дараа тоолж эхэлнэ.

2/6.12 дугаар зүйлийн 6 дахь хэсэг:

"6. Энэ хуулийн 10.1 дүгээр зүйлийн 2, 3 **10.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, 12.1 дүгээр зүйлийн 5 дахь 12.1 дүгээр зүйлийн 4 дэх** хэсэг, 12.3 дугаар зүйлийн 4.1 дэх заалт, 13.1 дүгээр зүйлийн 2, 3 дахь хэсэг, 22 дугаар бүлэгт **22.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, 22.4 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, 22.10 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт** заасан гэмт хэрэг үйлдсэн ялтныг хорих ялаас хугацаанаас өмнө суллаж, хяналт тогтоохгүй.

Тайлбар: -Гэмт хэрэг үйлдэх үедээ арван найман насанд хүрээгүй хүнд энэ зүйлийн 6 дахь хэсэг хамаарахгүй."

3/6.14 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг:

"3. Энэ хуулийн 10.1 дүгээр зүйлийн 2, 3 **10.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, 12.1 дүгээр зүйлийн 5 дахь 12.1 дүгээр зүйлийн 4 дэх** хэсэг, 12.3 дугаар зүйлийн 4.1 дэх заалт, 13.1 дүгээр зүйлийн 2, 3 дахь хэсэгт заасан гэмт хэрэгт өршөөл үзүүлэхгүй.

Тайлбар: -Гэмт хэрэг үйлдэх үедээ арван найман насанд хүрээгүй хүнд энэ зүйлийн 3 дахь хэсэг хамаарахгүй."

4/10.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг:

~~"3.Бага насын хүүхдийг алсан бол арван хоёр жилээс хорин таван жил хуртэл хугацаагаар, эсхүл бүх насаар нь хорих ял шийтгэнз."~~

~~2 дугаар зүйл.Эрүүгийн хуулийн 5.7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн "мэргэжлийн үйл ажиллагаа явуулах," гэсний дараа "тээврийн хэрэгслийг жолоодож" гэж, мөн хэсгийн "нийтийн албанд ажиллах" гэсний дараа "тээврийн хэрэгслийг жолоодож" "тохиолдолд" гэсний дараа "тээврийн хэрэгслийг жолоодох эрхийг нэг жилээс арван хоёр жил хуртэл, эсхүл" гэж, 12.2 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн "далимдуулж" гэсний дараа "бэлгийн шинжтэй тодорхой үйлдэл хийсэн, эсхүл хохирогчоор хийлгэж" гэж, мөн зүйлийн "Тайлбар хэсгийн "байж болно." гэсний дараа "-Бага насын хүүхдийн эсрэг энэ гэмт хэргийт үйлдсэнд тооцоход энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан аргаар үйлдсэн байхыг шаардахгүй." гэж, 12.3 дугаар зүйлийн 3.2 дахь заалтын "арван зургаан насанд" гэсний дараа "хурсон арван найман насанд" гэж тус тус нэмсүгэй.~~

~~3 дугаар зүйл.Эрүүгийн хуулийн дараах зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:~~

~~1/12.1 дүгээр зүйл:~~

~~"12.1 дүгээр зүйл.Хүчиндэх~~

~~1.Хохирогчийн хүсэл зэригийн сэргэ хүч хөрглэж, хүч хөрглэхээр занаяхийж, эсхүл сэтгэцийн овчтэй, сэгтүүреан, манууреан, сэтгэцийн үйл ажиллагаа нь түр сарнисан, бусад овчний улмаас биеэ хамгаалах, сэргүүцэл үзүүлэх чадваргүй, эсхүл од хөренгө, албан тушаал, бусад нохцол байдлын улмаас эржшээлээс байгааг далимдуулан бэлгийн харьцааны шинжтэй хүч хөрглөөнен үйлдэл хийсан бол нөг жилээс таван жил хуртэл хугацаагаар хорих ял шийтгено.~~

~~2.Хохирогчийн хүсэл зэригийн сэргэ энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан аргаар бэлгийн харьцаанд орсон бол хоёр жилээс найман жил хуртэл хугацаагаар хорих ял шийтгено.~~

~~3.Энэ зүйлийн 1, 2 дахь хэсэгт заасан гэмт хэргийн:~~

~~3.1.арван зургаан насанд хурсон арван найман насанд хүрэгүй хүний хүчиндэж;~~

~~3.2.булаглэж;~~

~~3.3.гор булийн хамаарал бүхий харилцаатай хүнийг хүчиндэж;~~

~~3.4.хөхирогчийг жиремсэн болгож;~~

~~3.5.хөхирогчид бэлгийн замын халдварт овчин халдааж;~~

~~3.6.хоёр түүнээс олон хүнийг хүчиндэж;~~

~~3.7.урьд нь энэ булагт заасан гэмт хэргийг үйлдэж гэм буруутайд тооцогдож байсан хүн;~~

~~3.8.хөхирогчийн зөрчих эрхийг хязгаарлаж;~~

~~3.9.такси үйлчилгээ үзүүлэхээр хуурган мэжэлж;~~

~~3.10.харгис хэрцгийн оргаар;~~

~~3.11.хөхирогчийг тохууржан дерэмжилж үйлдсэн бол таваас жилээс арван хоёр жил хуртэл хугацаагаар хорих ял шийтгено.~~

~~4. Энэ гэмт хөргийн улмаас ураг зулбсан, эсхүл энэ гэмт хөргийг арван дөрвөн насанд хурсан арван зураган насанд хуреэгүй хүний сорог үйлдсэн бол найман жилээс арван таван жил хүртэл хугацаагаар хөрих ял шийтгэнэ.~~

~~5. Энэ гэмт хөргийг арван дөрвөн насанд хуреэгүй хүний сорог үйлдсэн; энэ гэмт хөргийн улмаас хөхирогч нас барсан бол арван хоёр жилээс хөрин таван жил хүртэл хугацаагаар, эсхүл бүх насаар хөрих ял шийтгэнэ.~~

Тайябар: Хүчиндэх гэмт хөрөг үйлдсэн хүн бэлэн энэ гэмт хөргийн хөхирогч нь аль ч хүсийн хүн байж болж.

~~“Болгийн харьцааны шинжтэй хүн хөрөглэсэн үйлдэл” гэж хөхирогчийн биеийн аль нэг хөсөт болго орхтнаас оруулсан; хөхирогчийн болго орхтонд сөрийн бусад орхтон, эсхүл сөрээ айл оруулсаныг ойлгэнэ.~~

~~Арван дөрвөн насанд хуреэгүй хүний сорог энэ гэмт хөргийг үйлдсэнд тооцоход энэ зүйлийн 1 дэх хөсөт заасан аргаар үйлдсэн байжыг шаардахгүй.”~~

2 21.9 дүгээр зүйл:

“21.9 дүгээр зүйл. Мөрдөн шалгах ажиллагааны нууцыг задруулах

1. Мөрдөн шалгах ажиллагааны талаарх баримт, мэдээллийг олж мэдсэн хүн мөрдөн шалгах ажиллагааны талаарх баримт, мэдээллийг задруулсан бол дөрвөн зуун тавин нэгжээс таван мянга дөрвөн зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дечин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ.

2. Мөрдөн шалгах ажиллагааны талаар албаны үүргийн дагуу олж мэдсэн алба хаагч, ажилтан прокурорын зөвшөөрөлгүйгээр мөрдөн шалгах ажиллагааны талаарх баримт, мэдээллийг задруулсан бол нийтийн албанд ажиллах эрхийг нэг жилээс гурван жил хүртэл хугацаагаар хасаж хоёр зуун дечин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

3. Мөрдөн шалгах ажиллагааны нууцыг албаны үүргийн дагуу олж мэдсэн алба хаагч, ажилтан мөрдөн шалгах ажиллагааны нууцалсан баримт, мэдээллийг зориуд задруулж, нууцалсан гэрчийг илчилж хэрэг шалган шийдвэрлэх ажиллагаанд саад учруулсан бол нийтийн албанд ажиллах эрхийг гурван жилээс таван жил хүртэл хугацаагаар хасаж нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.”

3 27.10 дугаар зүйл:

“27.10 дугаар зүйл. Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зорчих

~~1. Тээврийн хэрэгслийн жолооч сэгтүүруулах ундаа, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолооддоюн, эсхүл сэгтүүруулах ундаа, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэсэн эсэхийг зөхж журмын дагуу шалгуулахаас зайлсхийсэн, эсхүл энэ үйлдлийн улмаас хүний эрүүл мэндэд хөнгөн хөхирол учруулсан бол тээврийн хэрэгслийг жолооддох эрхийг нэгжилээс гурван жил хүртэл хугацаагаар хасаж дервон зуун тавин нэгжээс хоёр мянга долоон зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр төрөх, эсхүл хоёр зуун дочин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл зургаан сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас хоёр жил хүртэл хугацаагаар хөрих ял шийтгэнэ.~~

~~2. Энэ зүйлийн 1 дахь хэсэгт заасан гэмт хэргийг үйлдэж гэм буруутайд тооцогдож байсан хүн дахин үйлдсэн бол тээврийн хэрэгслийг жолооддох эрхийг нэгжилээс гурван жил хүртэл хугацаагаар хасаж нэг мянга гурван зуун тавин нэгжээс авсан мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр төрөх, эсхүл хоёр зуун дочин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл зургаан сараас хоёр жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас хоёр жил хүртэл хугацаагаар хөрих ял шийтгэнэ.~~

~~3. Тээврийн хэрэгслийн жолооч хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, түүнд нийцүүлэн гаргасан захиргааны хэм хэмжээний актыг зарчсаний улмаас хүний эрүүл мэндэд хүндэвтэр хөхирол учруулсан бол тээврийн хэрэгслийг жолооддох эрхийг гурван жилээс таван жил хүртэл хугацаагаар хасаж хоёр мянга долоон зуун нэгжээс авсан дервон мянган нэгжтай тэнцэх хэмжээний төгрөгөөр төрөх, эсхүл хоёр зуун дочин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас хоёр жил хүртэл хугацаагаар хөрих ял шийтгэнэ.~~

4. Энэ зүйлийн 3 дахь хэсэгт заасан гэмт хэргийг:

~~4.1. сэгтүүруулах ундаа, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэсэн үедээ;~~

~~4.2. хүний эрүүл мэндэд хүнд хөхирол учруулж үйлдсэн бол тээврийн хэрэгслийг жолооддох эрхийг таван жилээс найман жил хүртэл хугацаагаар хасаж нэг жилээс гурван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс гурван жил хүртэл хугацаагаар хөрих ял шийтгэнэ.~~

~~5. Энэ зүйлийн 3 дахь хэсэгт заасан гэмт хэргийг тээврийн хэрэгслийг жолооддох эрхийг хүн үйлдсэн бол нэг жилээс гурван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс гурван жил хүртэл хугацаагаар хөрих ял шийтгэнэ.~~

~~6. Энэ гэмт хэргийн улмаас хүний амь нас хохирсон бол тээврийн хэрэгслийг жолооддох эрхийг таван жилээс найман жил хүртэл хугацаагаар хасаж нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хөрих ял шийтгэнэ.~~

7. Энэ зүйлийн 6 дахь хэсэгт заасан гэмт хэргийг:

~~7.1.согтууруулах ундаа, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэсэн үедээ;~~

~~7.2.энэ гэмт хэргийн улмаас хоёр, түүнээс олон хүний амь нас хохирсон бол тээврийн хэрэгслийг жолоодох эрхийг бүх насаар хасаж хоёр жилээс найман жилийн хуртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.~~

Тайлбар: Энэ зүйлд заасан "согтууруулах ундаа хэрэглэсэн" гэж шалгаж, тогтоох ажиллагааны үр дунд шалгуулагчийн амьсгал дахь спиртийн агууламж 0.20 промиль (%), эсхүл цусан дахь спиртийн агууламж 0.5 промиль (%) илэрснийг ойлгено."

"27.10 дугаар зүйл. Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих

1.Тээврийн хэрэгслийн жолооч хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль тогтоомж, түүнд нийцүүлэн гаргасан захиргааны хэм хэмжээний актыг зерчсений улмаас хүний эрүүл мэндэд хүндэвтэр хохирол учруулсан бол тээврийн хэрэгслийг жолоодох эрхийг нэг жилээс гурван жил хуртэл хугацаагаар хасаж хоёр мянга долоон зуун нэгжээс авсан дөрвөн мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зүүн дочин цагаас долоон зуун хорин цаг хуртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл зургаан сараас гурван жил хуртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ.

2.Энэ гэмт хэргийг:

2.1.согтуурсан, мансуурсан үедээ;

2.2.тээврийн хэрэгслийг жолоодох эрхгүй хун;

2.3.хүний эрүүл мэндэд хүнд хохирол учруулж үйлдсэн бол тээврийн хэрэгслийг жолоодох эрхийг гурван жилээс дээш таван жил хуртэл хугацаагаар хасаж нэг жилээс гурван жил хуртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс гурван жил хуртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

3.Энэ гэмт хэргийн улмаас хүний амь нас хохирсон бол тээврийн хэрэгслийг жолоодох эрхийг таван жилээс дээш найман жил хуртэл хугацаагаар хасаж нэг жилээс таван жил хуртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хуртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

4.Энэ зүйлийн 3 дахь хэсэгт заасан гэмт хэргийг:

4.1.согтуурсан, мансуурсан үедээ үйлдсэн;

4.2.энэ гэмт хэргийн улмаас хоёр, түүнээс олон хүний амь нас хохирсон бол тээврийн хэрэгслийг жолоодох эрхийг найман жилээс дээш авсан хоёр жил хуртэл хугацаагаар хасаж хоёр жилээс найман жил хуртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

5.Тээврийн хэрэгсэл жолоодох эрхээ хасуулсан хүн согтуурсан, мансуурсан үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон, эсхүл согтуурсан, мансуурсан эсэхийг зохих журмын дагуу шалгуулахаас зайлсхийсэн бол тээврийн хэрэгслийг жолоодох эрхийг нэг жилээс гурван жил хуртэл хугацаагаар хасаж

хоёр мянга долоон зуун нэгжээс арван дөрвөн мянган нэгжтэй тэнцэх хэмжээний тегрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дечин цагаас долоон зуун хорин цаг хуртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл зургаан сараас гурван жил хуртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас гурван жил хуртэл хугацаагаар хорих ял шийтгэнз.

Тайлбар: -Энэ зүйлд заасан “согтуурсан” гэж шалгаж, тогтоох ажиллагааны ур дунд шалгуулагчийн амьсгал дахь спиртийн агууламж 0.20, түүнээс дээш промиль (%), эсхүл цусан дахь спиртийн агууламж 0.5, түүнээс дээш промиль (%) илэрснийг ойлгоно.

-“Тээврийн хэрэгслийн жолооч” гэж тээврийн хэрэгсэл жолоодож яваа тээврийн хэрэгслийг жолоодох эрхтэй, эсхүл эрхгүй, эсхүл жолоодох эрх нь дуусгавар болсон хүнийг ойлгоно,

-“Тээврийн хэрэгсэл жолоодох эрхээ хасуулсан хүн” гэдэгт согтуурсан, мансуурсан үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон, эсхүл согтуурсан, мансуурсан эсэхийг зохих журмын дагуу шалгуулахаас зайлсхийсэн үйлдлийн улмаас тээврийн хэрэгсэл жолоодох эрхээ хасуулсан хүнийг ойлгоно,

-“Тээврийн хэрэгсэл” гэж механиюксан тээврийн хэрэгслийг ойлгоно.”

4 дүгээр зүйл. Эруүгийн хуулийн 5.6 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн, 12.1 дүгээр зүйлийн 4 дэх хэсгийн “хорин” гэснийг “хорин таван” гэж, мөн зүйлийн 6 дахь хэсгийн “хорин тав” гэснийг “гучин” гэж, 40.1 дүгээр зүйлийн Тайлбарын “арван дөрвөн” гэснийг “арван зургаан” гэж, 12.2 дугаар зүйлийн 2 дахь хэсэф, 12.3 дугаар зүйлийн 2.1 дэх заалтын “арван дөрвөө” гэснийг “арван зургаагаас” гэж, мөн зүйлийн 4.1 дэх заалтын “хүүхдийг албадан оруулж” гэснийг “хүүхдийн эсрэг” гэж тус тус өөрчилсүгэй.

5 дугаар зүйл. Эруүгийн хуулийн 10.1 дүгээр зүйлийн 2.7 дахь заалтын “бага насны хүүхэд,” гэснийг хассугай.

6 дугаар зүйл. Энэ хуулийг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрднө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 он ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ЗӨРЧЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Зөрчлийн тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах зүйл, хэсэг, заалт нэмсүгэй:

1/3.3 дугаар зүйлийн 1.2 дахь заалт:

"1.2. нийтэд тустай ажил хийлгэх;"

2/3.4 дүгээр зүйлийн 8, 9 дэх хэсэг:

"8. Зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээд нь эрх бүхий этгээдээс оногдуулсан тorgох шийтгэлийг хуульд заасан хугацаанд биелүүлзэгүй бол тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл хүсэх, сунгах, төндер шалгаруулалтад оролцох, териийн жинхэнэ албаны шалгалт өгөх, үндэсний гадаад паспорт авах, тээврийн хэрэгсэл жолоодох эрхийн үнэмлэх авах, сунгах, ангилал нэмэх, өөрчлөх, шинээр авах, тээврийн хэрэгслийн эзэмшилийн шилжилт хөдөлгөөн хийх эрхийг хязгаарлана.

9. Энэ-хуулийн Энэ зүйлийн 8 дахь хэсэгт заасан эрхийг хязгаарлах, эрх бүхий албан тушаалтан, шүүх болон эрх бүхий байгууллага хооронд мэдээлэл солилцох журмыг Улсын ерөнхий прокурор, хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална."

3/3.5, 3.6 дугаар зүйл:

"3.5 дугаар зүйл. Тorgох шийтгэлийн хэмжээг хөнгөрүүлэх,
нэмэгдүүлэх үндэслэл

1. Зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээд нь эрх бүхий албан тушаалтан, шүүхээс оногдуулсан тorgох шийтгэлийг хуулиар тогтоосон хугацаанд биелүүлэх бол шийтгэлийн хэмжээг тавин хувиар хөнгөрүүлнэ.

2. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан шийтгэлийн хэмжээг хөнгөрүүлсэн нь зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдэд албадлагын арга хэмжээ авахгүй байх үндэслэл болохгүй.

3. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу шийтгэлийн хэмжээг хөнгөрүүлэх үндэслэл нь 5.5, 5.9, 5.13 дугаар зүйлийн 4 дэх хэсэг, 5.14 дүгээр зүйлийн 6 дахь хэсэг,

~~5.17, 5.18, 6.5, 6.7, 6.8, 6.9, 6.16, 6.17, 7.1, 7.2, 7.3, 7.4, 7.5, 7.6, 7.7, 7.8, 7.9, 7.10, 7.11, 7.12, 7.13, 7.14, 7.15, 7.16, 8.7, 9.3, 9.4, 9.8, 9.9, 9.10, 9.11, 9.12, 10.2, 10.3, 10.5, 10.6, 10.7, 10.8, 10.14, 10.20, 10.24, 10.25, 10.30, 11.9, 14.2, 14.4, 14.8, 15.3, 15.4, 15.5, 15.6, 15.7, 15.9, 15.10, 15.11, 15.13, 15.18, 15.26, 15.29, 15.30, 15.33, 15.34, 16.1 дүгээр зүйлд заасан зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдэд хамаarahгүй.~~

3.Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу шийтгэлийн хэмжээг хөнгөруулэх үндэслэл нь энэ хуулийн 5.2, 5.3, 5.4, 5.5, 5.6, 5.7, 5.8, 5.10, 5.11, 5.12, 5.13, 5.14, 5.15, 5.18, 5.20, 6.4, 6.5, 6.6, 6.7, 6.8, 6.10, 6.11, 6.12, 6.14, 6.15, 6.17, 6.18, 6.20, 6.22, 6.23, 6.26, 6.27 дугаар зүйл, Долдугаар булэг, 8.1, 8.6, 8.7, 8.8, 8.9, 9.7, 10.3, 10.7, 10.15, 10.25 дугаар зүйл, Арван нэгдүгээр булэг, 12.1, 12.2, 12.3, 12.4, 12.5, 12.6, 12.8, 12.9, 12.10, 12.11, 13.1, 13.2, 13.4, 13.5, 13.6, 14.1, 14.2, 14.3, 14.4, 14.5, 14.6, 14.8, 14.9, 14.10, 14.11, 14.12, 14.13 дугаар зүйл, Арван тав, Арван зургадугаар булэг, 17.1 дугээр зуйлд тус тус заасан зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдэд хамаarahгүй.

4.Эрх бүхий албан тушаалтнаас оногдуулсан торгох шийтгэлийн энэ хуульд заасан хугацаанд биелүүлээгүй бол шийтгэлийн хэмжээг тавь хүртэл хувиар нэмэгдүүлнэ.

5.Энэ зүйлийн 4 дэх хэсэгт заасны дагуу торгох шийтгэлийг нэмэгдүүлж тооцох хугацаа, аргачлалыг Улсын ерөнхий прокурор, хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.

6.Шүүх, эрх бүхий албан тушаалтан торгох шийтгэлийг нэг жил хүртэл хугацаанд хэсэгчлэн төлүүлэхээр шийдвэрлэсэн бол энэ зүйлийн 1, 4 дэх хэсэг хамаarahгүй.

3.6.Нийтэд тустай ажил хийлгэх шийтгэл

1.Зөрчил үйлдсэн хүн энэ хуулийн 3.5 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасны дагуу торгох шийтгэлийг биелүүлээгүй бол шүүхээс тогтоосон нийтийн ашиг сонирхолд тустай ажлыг цалин хэлс олгохгүйгээр хийлгэхийг нийтэд тустай ажил хийлгэх шийтгэл гэнэ.

2.Шүүх нийтэд тустай ажил хийлгэх шийтгэлийг өдөрт наймаас дээшгүй цагаар, нийт хоёр зуун дечеөс долоон зуун хорин цагаар тогтооно.

3.Энэ хуулийн 3.5 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасан торгох шийтгэлийг биелүүлээгүй бол торгох шийтгэлийн 15 нэгжийг найман цагийн нийтэд тустай ажил хийлгэх шийтгэлээр тооцож солино.

4.Нийтэд тустай ажил хийлгэх шийтгэлийг хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан хүнд, биеийн эрүүл мэндэд шууд нөлөөлөхүйц нийтэд тустай ажил хийлгэх шийтгэлийг жирэмсэн эмэгтэй, тавин таваас дээш насны эмэгтэй, жараас дээш насны эрэгтэй хүнд оногдуулахгүй.”

2 дугаар зүйл.Зөрчлийн тухай хуулийн 3.3 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн “үндсэн,” гэсний дараа “нийтэд тустай ажил хийлгэх,” гэж нэмсүгэй.

"3 дугаар зүйл. Зөрчлийн тухай хуулийн 14.7 дугаар зүйлийн 5 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

5.Жолооч:

5.1. согтуурсан, мансуурсан үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон;

5.2. тээврийн хэрэгсэл жолоодох эрхгүй, эсхүл жолоодох эрх нь дуусгавар болсон хүн согтуурсан, мансуурсан үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон;

5.3. согтуурсан, мансуурсан эсэхийг зохих журмын дагуу шалгуулахаас зайлсхийсэн бол тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг нэг жилийн хугацаагаар хасаж дөрвөн зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл долоогоос гуч хоногийн хугацаагаар баривчлах шийтгэл оногдуулна."

3 дугаар 4 дүгээр зүйл. Зөрчлийн тухай хуулийн 3.3 дугаар зүйлийн 1.2, 1.3, 1.4 дэх заалтын дугаарыг "1.3, 1.4, 1.5;" гэж, "1.2., 1.3. дахь заалтын дугаарыг "1.3., 1.4." гэж, 3.5-3.8 дугаар зүйлийн дугаарыг "3.7-3.10" гэж, 14.7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн "хоёр зуун" гэснийг "дөрвөн зуун" гэж, 3.5-3.8 дугаар зүйлийн дугаарыг "3.7 3.10" гэж, тус тус өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл. Зөрчлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 9 дэх хэсгийн "14.7 дугаар зүйлийн 5 дахь" гэснийг хассугай.

5 дугаар зүйл. Зөрчлийн тухай хуулийн 14.7 дугаар зүйлийн 3, 5 дахь хэсгийг хүчингүй болсонд тооцеугай.

6 5 дугаар зүйл. Энэ хуулийг 20.. оны ... сарын ...-ны өдөр баталсан Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрднө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны ... дугаар
сарын ... ны өдөр

Улаанбаатар
хот

ЗӨРЧИЛ ШАЛГАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд доор дурдсан агуулга бүхий зүйл, хэсэг агуулгатай дараах зүйл, хэсэг, заалт нэмсүгэй:

1/7.1 дүгээр зүйлийн 1.7 дахь заалт:

"1.7. Зөрчлийн тухай хуулийн 3.5 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу торгох шийтгэлийг хөнгөрүүлэх, эсхүл нэмэгдүүлэх эсэх."

3/ 7.6 дугаар зүйл:

"7.6 дугаар зүйл. Торгох шийтгэлийг хөнгөрүүлэх, нэмэгдүүлэх

1. Шийтгэлийн хуудсанд заасан торгох шийтгэлийг хэсэгчлэн төлүүлэх шийдвэр нь торгох шийтгэлийг хөнгөрүүлсэн нөхцөлд хамаарахгүй.

2. Зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээд торгох шийтгэлийг энэ хуулийн 7.5 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан хугацаанд багтаан бүрэн төлнэ.

3. Зөрчил үйлдсэн хүн Зөрчлийн тухай хуулийн 3.5 дугаар зүйлийн 4 дэх хэсэг заасан торгох шийтгэлийг биелүүлээгүй бол эрх бүхий албан тушаалтан нийтэд тустай ажил хийлгэх шийтгэлээр солих саналаа оршин суугаа /оршин байгаа/ газар, эсхүл тухай зөрчил гаргасан харьяаллын шүүхэд хүргүүлнэ."

2 дугаар зүйл. Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 6.6 дугаар зүйлийн 8 дахь хэсэг, 6.12 дугаар зүйлийн 12 дахь хэсэг, 7.3 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, 8.1 дүгээр зүйлийн 14 дэх хэсэг, 7.5 дугаар зүйлийн 8 дахь хэсгийн "7.6 гэснийг "7.7" гэж, 7.6 дугаар зүйлийн дугаарыг "7.7." гэж тус тус өөрчилсүгэй.

3 дугаар зүйл. Энэ хуулийг 20.. оны ... сарын ...-ны өдөр баталсан Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны ... дугаар
сарын ... ны өдөр

Улаанбаатар
хот

**ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд доор дурдсан агуулгатай 151¹ дүгээр зүйл нэмсүгэй:

"151¹ дүгээр зүйл. Нийтэд тустай ажил хийлгэх шийтгэлийг гүйцэтгэх

151¹.1. Нийтэд тустай ажил хийлгэх шийтгэлийг гүйцэтгэх ажиллагааг эхлүүлэх,
зохион байгуулах ажиллагааг гүйцэтгэхэд энэ хуулийн 162, 163, 164 дүгээр зүйлд заасан журмыг баримтална."

2 дугаар зүйл.20.. оны ... сарын ...-ны өдөр баталсан Эрүүгийн хуульд нэмэлт,
өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөне.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах хэсэг нэмсүгэй:

1/32 дугаар зүйлийн 32.10, 32.11 дахь хэсэг:

"32.10. Цагдаагийн байгууллагаас ирүүлсэн бага насын хүүхэд сургтай алга болсон, одсон тухай хойшлуулшгүй мэдээллийг харилцаа холбооны үйлчилгээ эрхлэгч этгээд үнэ төлбөргүй, нийтэд мэдээлнэ.

32.11. Энэ хуулийн 32.10-т заасан ажиллагааг зохицуулах журмыг хууль зүйн болон харилцаа холбооны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална."

2/41 дүгээр зүйлийн 41.2 дахь хэсэг:

"41.2. Эрүүгийн хуулийн 10.1 дүгээр зүйлийн 2, 3 дахь хэсэг, 12.1 дүгээр зүйлийн 5-дахь 4 дэх хэсэг, 12.3 дугаар зүйлийн 4.1 дэх заалт, 13.1 дүгээр зүйлийн 2, 3 дахь хэсэгт заасан гэмт хэрэг үйлдэж, хорих ял здэлж дууссан, Эрүүгийн хуулийн 6.13 дугаар зүйлд заасны дагуу хорих ялаас өвчний учир чөлөөлөгдсөн болон Эрүүгийн хуулийн 6.14 дүгээр зүйлд заасны дагуу уччалд хамрагдсан хүний зорчих хөдөлгөөнд тоног төхөөрөмж ашиглан хяналт тогтооно."

3/41 дүгээр зүйлийн 41.7 дахь хэсэг:

"41.7. Энэ хуулийн 41.2-т заасан зорчих хөдөлгөөнд хяналт тавих тоног төхөөрөмжийн жагсаалт, тэдгээрийг ашиглах журмыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална."

4/42 дугаар зүйлийн 42.2 дахь хэсэг:

"42.2. Энэ хуулийн 41.2-т заасан хүнд шүүхээс оногдуулсан хорих ялын хоёрны нэгзээс доошгүй хугацаагаар нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын даргын шийдвэрээр хяналт тогтооно."

5/44 дүгээр зүйлийн 44.2 дахь хэсэг:

"44.2.Энэ хуулийн 41.2-т заасан хяналтад байгаа этгээдийн бүртгэлийг цагдаагийн байгууллага хөтөлнө."

2 дугаар зүйл.Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 32 дугаар зүйлийн гарчгийн "урьдчилан сэргийлэх талаар" гэсний дараа "харилцаа холбоо," гэж нэмсүгэй.

3 дугаар зүйл.Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2-41.5 дахь хэсгийн дугаарыг "41.3-41.6" гэж, мөн зүйлийн 41.2 дахь хэсгийн "41.1-д" гэснийг "41.1, 41.2-т" гэж, мөн зүйлийн 41.4 дахь хэсгийн "41.1-д" гэснийг "41.1, 41.2-т" гэж, 42 дугаар зүйлийн 42.2-42.7 дахь хэсгийн дугаарыг "42.3-42.8" гэж, мөн зүйлийн 42.6 дахь хэсгийн "42.2, 42.3, 42.4-т" гэснийг "42.3, 42.4, 42.5-д" гэж тус тус өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл.Энэ хуулийн 41.2 дахь хэсгийг 2024-оны ... дүгээр/дугаар-сарын ...-ны 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөх бөгөөд шаардагдах зардлыг Монгол Улсын Засгийн газар холбогдох хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэнэ.

5 дугаар зүйл.Энэ хуулийг 20.. оны ... сарын ...-ны өдөр баталсан Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг